



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 01 болон 02 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 01-р сарын 01-нээс 01-р сарын 14-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны эхний дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- ОУВС-ийн Ерөнхий эдийн засагч Гита Гопинат CNBC-д өгсөн ярилцлагадаа “Дэлхийн ихэнх өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг 2021 оны сүүлийн хагас гэхэд хэвийн төлөвт орох хүлээлттэй байна” гэжээ. ОУВС-аас 2020 оны 10-р сард нийтэлсэн “Дэлхийн Эдийн Засгийн Төлөв” тайланд дэлхийн эдийн засаг 2020 онд 4.4 хувиар агшиж, 2021 онд 5.2 хувиар өсөх бол АНУ-ын эдийн засаг 2020 онд 4.3 хувиар агшиж, 2021 онд 3.1 хувиар өсөхөөр таамаглаж байв. Тэгвэл КОВИД-19-ийн вакцин бий болсон нөлөөгөөр энэхүү таамаглал тун удахгүй шинэчлэгдэхээр байгааг Гита Гопинат дурджээ. Мөн тэрээр дэлхийн улс орнуудын эдийн засгийн сэргэлт харилцан адилгүй байхаар байгаа хэдий ч 2022 он гэхэд бүрэн сэргэх хүлээлттэй байгаа бөгөөд Төв банкууд болон засгийн газрууд санхүүжилтийн багц хөтөлбөр, тэтгэмжүүдээ зогсоохдоо маш бодлоготой хандах хэрэгтэйг анхааруулжээ.
- Дэлхийн банк “Глобал эдийн засгийн төлөв” тайлангийн шинэ дугаараа 2021 оны 1-р сард нийтэллээ. Шинэчилсэн төсөөллөөр дэлхийн эдийн засаг 2021

онд 4 хувиар өсөхөөр байгаа нь өмнөх төсөөлөл буюу 2020 оны 6-р сарын төсөөллөөс 0.2 нэгж хувиар бага байна. Харин 2022 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3.8 хувь болж саарахаар байгаа нь цар тахлын эдийн засагт нөлөөлөх урт хугацааны сөрөг үр дагавруудтай холбоотой байна. Бүс нутгаар авч үзвэл цар тахлын тархалт өндөр байгаа АНУ болон Евро бүсийн эдийн засгийн төлөв муудаж байна. Тухайлбал, АНУ-ын эдийн засаг өмнөх төсөөллөөс 0.5 нэгж хувиар буурч 3.5 хувиар, Евро бүсийн эдийн засаг 0.9 нэгж хувиар муудаж 3.6 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Харин халдварын тархалтыг хяналтдаа аваад буй БНХАУ-ын эдийн засаг өмнөх төсөөллөөс 1 нэгж хувиар нэмэгдэж 7.9 хувиар өсөх төлөвтэй. Цаашид дэлхийн эдийн засгийн сэргэлт вакцинжуулалтаас ихээхэн хамаарах бөгөөд цар тахал хэр удаан үргэлжлэхээс шалтгаалж өрийн дарамт нэмэгдэх, бизнесүүд бүрмөсөн зогсох, ажилгүйдэл нэмэгдэх зэрэг эрсдэлүүд өндөр хэвээр байна. Түүнчлэн, уг тайланд засгийн газрууд бизнесийн орчин, боловсрол, бүтээмжийг сайжруулах дорвитой арга



хэмжээнүүдийг авахгүй бол эдийн засгийн өсөлтийн хурдыг 10 орчим жилээр хойш татах эрсдэлтэйг анхааруулжээ.

- Европын Төв банкны 2020 оны 12-р сарын төсөөллөөр **Евро бүсийн эдийн засаг** 2020 онд 7.3 хувиар агшсаны дараа **2021 онд 3.9 хувиар өсөхөөр** тооцоолсон. Уг төсөөллөөс хойш Европын улс орнууд дахин хатуу хөл хорио тогтоогоод байгаа ч эдийн засгийн төлөвт 12-р сараас хойш төдийлөн өөрчлөлт орохооргүй байгааг Европын Төв банкны Ерөнхийлөгч Кристин Лагард 1-р сарын эхээр Reuters агентлагийн арга хэмжээн дээр мэдээлжээ. Тэрээр энэ оны 3-р сар хүртэл цар тахлын нөхцөл байдал хэр байхаас эдийн засгийн төлөв хүчтэй хамаарахаар байгааг онцолсон бөгөөд хэрэв вакцинжуулалт удааширсан хэвээр, улс орнууд 3-р сараас хойш хөл хориог үргэлжлүүлэх тохиолдолд Евро бүс төдийгүй дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч болзошгүйг анхаарууллаа.
- АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулиас хийсэн судалгаагаар

КОВИД-19-ийн халдвар Европ болон АНУ-тай харьцуулахад Азийн орнуудад харьцангуй бага байна. Гэсэн хэдий ч Азийн томоохон эдийн засагтай орнууд болох Япон болон Өмнөд Солонгост цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдал 2020 оны эхний давалгаанаас хүнд байгаа тул бүсийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлөхөөр байна.

- **АНУ-ын цалинтай ажиллагсдын тоо** (payroll employment) **2020 оны 12-р сард** өмнөх сараас 140,000-аар, өмнөх оны мөн үеэс **9.4 саяар буурлаа**. Энэ нь 2020 оны 4-р сараас хойш анх удаа буурсан үзүүлэлт болов. Ажилгүйдлийн түвшин 6.7 хувь буюу өмнөх сарын түвшинд байна.

Эх сурвалж:

1. CNBC, [IMF's top economist expects a global recovery in the second half of the year](#)
2. CNBC, [Covid resurgence in some parts of Asia could threaten the region's economic recovery](#)
3. CNBC, [Lagarde stands by growth forecasts despite new lockdowns hitting Europe](#)
4. World Bank, [Global Economic Prospects – January 2021](#)
5. BLS, [Bureau of Labor Statistics](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- БНХАУ-ын Статистикийн үндэсний хорооноос 1-р сарын 18-нд ДНБ-ий гүйцэтгэлийг зарлалаа. БНХАУ-ын эдийн засаг 2020 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсч, жилийн 2.3 хувийн өсөлттэй гарлаа. Үүнд экспорт өсөлтийг тэтгэх гол хүчин зүйл болсон бол дотоод хэрэглээ хүлээлтээс бага байжээ. Reuters агентлагаас 46 эдийн засагчдын дунд явуулсан түүвэр судалгааны медиан утгаар БНХАУ-ын эдийн засгийн

өсөлтийг 2020 оны 4-р улиралд 6.1 хувь байхаар таамаглаж байсан юм.

- **БНХАУ-ын экспорт нэмэгдэж, гадаад худалдааны ашиг нэмэгдэж байна.** БНХАУ-ын экспорт, импорт 12-р сард хүлээлтээс давж 18.1 хувь, 6.5 хувиар тус тус өсчээ. Улмаар экспорт 7 дахь сардаа, импорт 4 дэх сардаа дараалан өсч байгаа юм. БНХАУ-ын гадаад худалдааны ашиг 78.2 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд хэмжээнд хүрээд байна. Экспорт хүлээлтээс

өндөр өсөлттэй гарахад 12-р сарын PMI индексийн судалгаагаар шинэ захиалгын бүрэлдэхүүн хэсэг 4 дэх сардаа тэлэлттэй гарсан, КОВИД-19-тэй холбоотой эрүүл мэндийн хангамжийн эрэлт өндөр байсан нь нөлөөлөв. БНХАУ-ын нийт экспорт 2020 онд жилийн 3.6 хувиар өссөн бол импорт 1.1 хувиар агшиж, гадаад худалдааны ашиг жилийн 535 тэрбум ам.долларт хүрсэн нь 2015 оноос хойш хамгийн өндөр дүн юм. Улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж, 2021 оны сүүлийн хагаст гадаад эрэлт тогтворжих хүлээлттэй тул БНХАУ-ын экспортын өндөр эрэлт цаашид одоогийн түвшинд хадгалагдаж чадахгүй гэж шинжээчид харж байна.

- **БНХАУ-ын хэрэглээний үнийн индекс** 11-р сард 0.5 хувиар буураад байсан бол 12-р сард хүлээлтээс өндөр буюу өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өслөө. ХҮИ ийнхүү хүлээлтээс давж өсөхөд өмнөх жилүүдээс илүү хүйтэн өвөл болж буй нөлөөгөөр хүнсний үнэ жилийн 1.2 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.
- **Үндсэн хөрөнгийн (fixed asset investment) хөрөнгө оруулалт** 2020 оны эхний 11 сард 50 их наяд юаниар буюу жилийн 2.6 хувиар өссөнөөс хувийн сектор дахь хөрөнгө оруулалт 27.8 их наяд юаниар буюу жилийн 0.2 хувиар өссөн нь 2020 оны анхны эерэг өсөлт болов. Харин боловсруулах салбар дахь хөрөнгө оруулалт 2020 оны 11-р сард жилийн 3.5 хувиар буурсан бол дэд бүтцийн барилга байгууламж дахь хөрөнгө оруулалт 1 хувиар нэмэгдсэн байна.
- **Автомашин** худалдаа 2020 оны эхний 11 сард 22.5 саяд хүрч өмнөх оны үеэс 2.9 хувиар буурсан бол автомашины үйлдвэрлэл эхний 11 сард 21.8 саяд хүрч 2.7 хувиар буурч,

бууралт нь багасчээ. Харин автомашин үйлдвэрлэл 11-р сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсч, тухайн сард 2.8 сая автомашин үйлдвэрлэсэн нь өмнөх сараас 12.2 хувиар нэмэгдэв. Автомашины худалдаа 11-р сард өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өсч 2.8 сая нэгж борлуулагдсан нь өмнөх сараас 7.6 хувиар өссөн дүн юм.

- **БНХАУ-ын дотоодын үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт** 2020 оны эхний 11 сард 12.9 их наяд юань хүрч өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар нэмэгдсэнээс орон сууцны хөрөнгө оруулалт жилийн 7.4 хувиар өсч, 9.6 их наяд юаньд хүрч сэргэлт хадгалагдаж байна.
- **2020 оны эхний 11 сард БНХАУ-ын Монгол Улсаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ** 22.8 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 29 хувиар буурсан бол **Австралиас импортолсон коксжих нүүрсний хэмжээ** 15 хувиар нэмэгдэж 35.36 сая тоннд, Канадаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 38.1 хувиар өсч 4.15 сая тоннд, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 2.2 хувиар өсч, 5.55 сая тоннд тус тус хүрчээ.
- **БНХАУ-ын гангийн импорт** 2020 оны эхний 11 сард нийт 18.86 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 77.5 хувиар нэмэгдсэн ч **11-р сард** 1.85 сая тонн байсан нь өмнөх оны мөн үеэс **4.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.**
- Дотоод эдийн засгийн идэвхжил бага зэрэг буурч, БНХАУ-ын Ардын Банкны дэмжлэг оны эцэс рүү багассанаар **БНХАУ-ын зээл олголт 2020 оны 12-р сард өмнөх сараас бага зэрэг буурлаа.** Үүнд:
 - а) Нийгмийн нийт санхүүжилт (social aggregate funding) 11-р сард өмнөх сараас 2.1 их наяд юаниар өссөн бол



12-р сард хүлээлтэд нийцтэйгээр 1.7 их наяд юаниар өсөв.

- b) Шинээр олгосон зээлийн хэмжээ 11-р сард 1.4 их наяд юань байсан бол 12-р сард 1.3 их наяд юань хүрч буурчээ. Мөнгөний нийлүүлэлт 11-р сард өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар, 12-р сард 10.1 хувиар тус тус нэмэгдэв.
- c) 2020 оны 11-р сард корпорацуудад бондоор дамжуулан 86.2 тэрбум

юанийн санхүүжилт олгосон бол 12-р сард уг дүн 44.2 тэрбум юань хүрч өмнөх сараас эрс буурав.

Эх сурвалж:

1. *China React: Unexpectedly weak credit won't shift PBOC's stance, Bloomberg*
2. *China React: CPI Gains driven by cold weather likely short-lived, Bloomberg*
3. *Coking coal monthly report, December, Sxcoal.com*




3


МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/01/12	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	7964.5	0.0%	-1.0%	3.0%	1.5%	27.1%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ хадгалагдахад нөлөөлж байна.
Төмрийн хүдэр	162.3	0.0%	2.2%	14.8%	6.1%	81.9%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлттэй тул төмрийн хүдрийн эрэлт сайн байх төлөвтэй бөгөөд хүйтэн өвөл болж буйтай холбоотойгоор коксжих нүүрсний эрэлт өндөр байхаар байгаа нь үнэ нэмэгдэхэд нөлөөлж байна.
Алт	1848.8	-0.3%	-3.6%	1.2%	-4.8%	19.6%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал бүрэн буураагүй, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна. Гэсэн хэдий ч улс орнуудад вакцинжуулалт эхэлсэн гэсэн мэдээ зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулж алтны үнэ буурахад нөлөөлөв.
Газрын тос (Брент)	56	-1.0%	3.2%	11.4%	9.7%	-12.7%	КОВИД-19-ийн тархалт нэмэгдэж байгаатай нь газрын тосны үнийг бууруулах чиглэлд нөлөөлж байна. Харин улс орнуудад вакцинжуулалт амжилттай болж буй мэдээ үнийг өсгөх чиглэлд нөлөөлж байна. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2021 оны дунд хүртэл төдийлөн нэмэгдэхээргүй байна.

Зураг 1. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 2. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ



Эх сурвалж: Блумберг